

МУИС-д СУРАЛЦАХ ЭРХИЙН БИЧИГ АВСАН ГАДААДЫН ИРГЭДЭД ӨГӨХ САНАМЖ

Элсэгч та дараах мэдээлэлтэй танилцаж, Монгол улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн Монгол улсын визийн талаарх заалтуудтай танилцаж судална уу.

1. **Монгол улсад нэвтрэх виз авах:** Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар МУИС-д суралцах эрхийн бичиг авсан гадаадын иргэн нь Монгол улсад нэвтрэх визийн эрх бүхий 4 оронтой кодыг цахим шуудангаар хүлээн авна. Хүлээн авсан кодыг виз мэдүүлэх ЭСЯ, консулын газарт хэлж, Монгол улсад нэвтрэх виз даруулна. МУИС-д элсэх хүсэлт гаргаж байх хугацаанд Монгол улсад оршин суух зөвшөөрөл авсан, ажлын, байгууллагын визтэй бол МУИС-ийн урилгаар виз авах шаардлагагүй болохыг анхаарна уу. Өмнө нь Монгол улсад байх хугацаанд виз, оршин суух зөвшөөрлийн зөрчил гаргасан бол виз олгогдохгүй байх магадлалтайг анхаарна уу.
2. **Түр бүртгэлд хамрагдах:** Гадаадын иргэний эрх зүйн байдлыг тухай хуулийн 24 дүгээр зүйлд зааснаар Монгол улсын хилээр нэвтэрсний дараа ажлын 3 өдрийн дотор Оюутан, төгсөгч хариуцсан нэгжид (МУИС-ийн хичээлийн 2-р байр, 200 тоот) бичиг баримтын хамт ирж бүртгэлд хамрагдана. Үүнд:паспорт эх хувиар, 1 хувь цээж зураг (4х6хэмжээтэй), 1500 төгрөгний хамт бүртгүүлэх. Хэрэв Та Гадаадын Иргэн Харьяатын Газар (цаашид ГИХГ гэх)-т ажлын 7 өдрийн дотор бүртгүүлээгүй тохиолдолд 2.500.000 төгрөгтэй тэнцэх торгууль төлөх ба цаашид оршин суух зөвшөөрөл авах боломжгүй болохыг анхаарна уу.
3. **Оршин суух зөвшөөрөл:** Гадаадын иргэний эрх зүйн байдлын хуулийн 27.2.5-д зааснаар түр бүртгэлд хамрагдсаны дараа хуанлийн 14 өдрийн дотор оршин суух зөвшөөрөл буюу оршин суух үнэмлэх авах ёстой. Гадаадын иргэн оршин суух зөвшөөрөл авахдаа Оюутан, төгсөгч хариуцсан нэгжид бичиг баримтын хамт ирж шаардлагатай албан бичгийг аван ГИХГ-т мэдүүлж оршин суух зөвшөөрөл авна. Үүнд: паспорт, паспортын хуулбар, 1 хувь цээж зураг (4х6 хэмжээтэй), оршин суугаа хаягийн хорооны тодорхойлолт, оршин суух зөвшөөрөл авах анкет, 36,500 төгрөгний хамт мэдүүлэх. Та дурдсан хугацаанд ирж оршин суух бүртгэл хийгээгүй тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээж торгууль төлөхийг анхаарна уу.
4. МУИС-ийн Зэргийн бус сургалтад хамрагдаж буй гадаад иргэдийг өөр сургуульд шилжүүлэн суралцуулахгүй бөгөөд шилжин суралцах хүсэлт гаргасан тохиолдолд МУИС-ийн урилгыг цуцалж хасалтыг хийхийг анхаарна уу.

Миний бие овогтой нь дээрх санамжтай танилцаж, Монгол улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн тохиолдолд өөрөө хариуцлага хүлээхийг хүлээн зөвшөөрч байна.

Овог нэр:

Паспортын дугаар:

Гарын үсэг:

Он сар өдөр:

PLEDGE OF NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA INTERNATIONAL STUDENT

Dear Applicant, please acquaintance yourself with the following information about getting a visa to enter Mongolia and the residence permit regulations as you will bear the responsibilities further.
/Mongolian Immigration Office/

1. **To get a visa to enter Mongolia.** According to Article 21 of the Regulation on the Legal Status of Foreign Citizens an applicant who has obtained an acceptance letter or letter of invitation from the National University of Mongolia will receive a four-digit code for applying visa by e-mail. Applicant should contact Embassy or Consulate of Mongolia in home country. After reporting the received code to the embassy or consulate, the visa to enter Mongolia will be issued. Please note that you do not need a visa to enter Mongolia if you have a residence permit in Mongolia or already issued for a work or corporate visa at the time of applying to the National University of Mongolia. Please note that visa may not be issued if you have previously violated visa or residence permit legislation during your stay in Mongolia.
2. **Temporary registration:** According to Article 24 of the Regulation on the Legal Status of Foreign Citizens, students must within 3 working days after entering Mongolia come to the Student and Alumni Office of NUM (NUM Building 2, Room 200) to register. Student must bring original passport, 1 ID photo (4x6 size) and 1500 MNT to register. Please note that if you do not get registered to the Mongolian Immigration Office within 7 working days, you will be fined 2,500,000 MNT and will not be able to obtain a residence permit in the future.
3. **Residence permit:** According to Article 27.2.5 of the Regulation on the Legal Status of Foreign Citizens, student must obtain a residence permit or certificate of alien registration within 14 calendar days after registration. To obtain a residence permit, student must come to Student and Alumni Office with the required documents. These include: original passport, copy of passport, 1 ID photo (4x6 size), current address reference, application form for a residence permit, and 36,500 MNT. Please note that if you do not issue documents within the specified time, you will be liable and pay large sum of fine according to the law.
4. Foreigners enrolled in the NUM non-degree program will not be transferred to another school, and please note that the NUM's invitation will be revoked if you decide to transfer.

I(First name, Last name) familiarized myself with the information above and agree to take the responsibilities in case of violation of the relevant provisions of the Regulation on the Legal Status of Foreign Citizens.

Last name, First name:

Passport No:

Signature:

Date: